

**ХУДАЛДАН АВАЛТ, ГЭРЭЭЛЭЛТИЙН ГАЗРЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ГЭРЭЭЛЭЛТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ДАШНЯМЫН МӨНХТУЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин (Биелэлт)	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1.3 Цахим шилжилтэд бүрэн шилжинэ.							
1.	МУТЖҮЧ-2.2.5, ЗГУАХ-2.1.7 Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын гэрээ, гэрээний мэдээллийг бүртгэж, цахим мэдээллийн нэгдсэн сан үүсгэнэ.	Баяжилт хийгдсэн мэдээллийн сан	www.selection.1818.mn -д лавлагаа шатлалын 321, Анхан шатны 552 ЭМБ-ын мэдээллийг бүртгэсэн.	Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн систем www.selection.1818.mn -д нэмэлт хөгжүүлэлт хийж, бүртгэл мэдээллийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.	Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn -д 2025 онд дараах хөгжүүлэлтүүдийг хийлгэж, бүртгэл мэдээллүүдийг шинэчилж ажиллаа. Үүнд: - 2025 онд шинээр байгуулагдсан 2, эмнэлгийн төрөл нь өөрчлөгдсөн 1, нийт 3 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тус програмд нэвтрэх эрхийг олгож, холбогдох мэдээллийг бүртгүүлээ. -Гэрээлэлт –Анхан шат цэсэнд 2025 он гэсэн цэсийг шинээр үүсгүүлэн 2025 онд гэрээ байгуулсан 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувийг олгоход шаардагдах гүйцэтгэлийг үнэлэх 7 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг сар бүрээр нь оруулах талбарыг үүсгүүлж 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшний саналыг авч, хүрэх түвшинг сар бүрээр нь	01.02 12.31	100

					<p>тооцоолон гаргаж сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн систем оруулсан.</p> <p>-2025 онд зохион байгуулах сонгон шалгаруулалтын мэдээллийг баазыг бүрдүүлэх болон 2025 оны гэрээлэлтийг хийх ажлын хүрээнд сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-д “Нөөцийн мэдээлэл” цэсийг үүсгүүлэн гэрээт анхан шатны 555 эрүүл мэндийн байгууллага, лавлагаа шатлалын 321 эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, тоног төхөөрөмж, тусгай нэгж байгууламжийн мэдээллийг тус програмд шинэчлүүлэх тухай зарыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын цахим хуудаст 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр байршуулж, мөн лавлагаа шатлалын Эрүүл мэндийн байгууллага бүрт 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 05/4367 дугаартай, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05/225 дугаартай албан бичгүүдийг тус тус хүргүүлж, нөөцийн мэдээллүүдийг шинэчлүүлсэн. Тус мэдээллийн баазыг бүрдүүлснээр эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрөл дэх үйл ажиллагааны чиглэл, бүс нутгийн байршил, хүний нөөц, тоног төхөөрөмж, орны тоо зэргийг харгалзан сонгон шалгаруулалтыг үнэн зөв бодитой хуулийн хүрээнд ил тод зохион байгуулах нөхцөл бүрдэх юм. Одоогоор сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-д “Нөөцийн судалгаа” цэсэнд 876 эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн мэдээллийг шинэчлэн бүртгүүлсэн байна.</p> <p>Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийг цаашид</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>үргэлжлүүлэн нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, эсвэл тус програм дахь дата бааз мэдээллийг хүлээн авч өөр програмыг шинээр хийх талаар зөвшилцөж уулзалтуудыг холбогдох хэлтэс болон зөвлөхүүд, програмын админтай зохион байгуулж байна.</p> <p>Үр дүн: Сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн систем www.selection.1818.mn-ний "Нөөцийн судалгаа" цэсэнд 876 эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн мэдээллийг шинэчлэн бүртгүүлсэн байна.</p>		
2.	Гэрээт анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацааны мэдээллийг тухай бүрт нь цахим системд өөрчлөлт хийлгэнэ.	Цахим системд өөрчлөлт хийлгэсэн мэдээллийн тоо	-	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн хугацаа сунгагдсан мэдээллийг МТХ-т хүргүүлж, бүртгэл мэдээллийн үнэн байдалд хяналт хийсэн байна	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамны магадлан итгэмжлэлийн комиссоос ирүүлсэн 6 албан бичгийн дагуу 62 анхан шатны эрүүл мэндийн байгууллага, 17 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа сунгагдсан мэдээллийг 6 удаагийн дотоод албан бичгээр Мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлж, эрүүл мэндийн даатгалын цахим програмд бүртгэлийн мэдээллийг шинэчлүүлж ажиллаа.	01.02 12.31	100
Зорилт 1.4. Салбарын хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгоно.							
3.	ЭМДТХ-10.1, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.12 "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Шинэчлэгдэн батлагдсан журам	ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/61, 2023 оны А/01 дүгээр тушаал хэрэгжсэн.	-	Хугацаа болоогүй.	07.01 12.31	-

	худалдан авах гэрээний хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх нийтлэг журам"-ыг шинэчлэн баталж, мөрдүүлнэ.						
4.	"Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг шинэчлэн батлуулж, мөрдөнө.	Шинэчлэн батлагдсан тогтоол	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 13 дугаар тогтоол хэрэгжсэн.	-	Хугацаа болоогүй.	08.01 12.31	-
Зорилт 1.5. Хөндлөнгийн хяналтад тулгуурласан хамтын ажиллагааг бэхжүүлнэ.							
5.	БСТ-1.4.1 Иргэн даатгуулагчийн хөндлөнгийн хяналтыг бий болгоно.	Мессежээр мэдээлэл ирүүлсэн иргэдийн тоо	Иргэд, даатгуулагчдад авсан тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийг мессежээр хүргэн, үр дүнг тооцон ажилласан.	-	Хугацаа болоогүй.	07.01 12.31	-
6.	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, холбогдох	-	Шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо	Ирүүлсэн гомдол мэдээллийг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна.	Тайлант хугацаанд 9 өргөдөл гомдол албан хэрэг хөтлөлтийн able програмаар цохогдон ирснээс 5 өргөдөл Засгийн газрын 11-11 төвөөс, 2 өргөдөл 1800-1363 төвөөс, 2 өргөдөл цаасан хэлбэрээр ирсэн байсан бөгөөд тус гомдлуудыг хуулийн хүрээнд шийдвэрлэн иргэнд хариуг өгч ажиллаа.	01.02 12.31	100

	байгууллагатай хамтран ажиллана.				Үр дүн: Нийт 9 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа.		
Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна.							
Зорилт 3.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна.							
7.	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо, гэрээний хэрэгжилтийн хувь	-	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний хэрэгжилтийн үнэлгээний дүнг нэгтгэх, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	2024 онд Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулсан 552 анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлыг зохион байгуулж 21 аймаг, 2 дүүрэг дэх Эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд гэрээг хэрхэн дүгнэх талаар мэргэжил аргагүйгээр хангах сургалтыг зохион байгуулж, 2024 оны гэрээг дүгнэсэн үр дүнг нэгтгэн, үнэлгээний үр дүнг тайлагнасан. 2024 онд гэрээтэй ажилласан 552 анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас маш сайн буюу 90 ба түүнээс дээш үнэлгээтэй 184, хангалттай буюу 70 ба түүнээс дээш үнэлгээтэй 268, хангалтгүй буюу 69.9 ба түүнээс доош үнэлгээгээр 100 байгууллага үнэлэгдсэн бөгөөд хангалтгүй үнэлэгдсэн 100 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан бөгөөд гэрээний хэрэгжилтийн үнэлгээг ЭМДЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталгаажууллаа. 2025 онд шинээр үүсгэн байгуулагдсан 2 өрхийн эрүүл мэндийн төв болон Багахангай дүүргийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ нь анхан шатны тусламж үйлчилгээнд шилжсэнтэй холбоотой 2025.02.01-ний өдрөөс гэрээ хийж нийт 3	01.02 03.01	100

					байгууллагатай гэрээ байгуулж, Дундговь аймгийн Боржигон мандал ӨЭМТ татан буугдсан шалтгаанаар гэрээ цуцалж 2025 онд нийт 554 эрүүл мэндийн байгууллагатай гэрээтэй ажиллаж байна. <i>Үр дүн: Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны гэрээний хэрэгжилт 82.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.61 хувиар өссөн дүнтэй байна.</i>		
8.	Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	Байгуулсан гэрээний тоо	37 эмийн сан, гэрээ байгуулан ажилласан.	Гэрээний хэрэгжилт хангалттай үнэлэгдсэн эмийн сангийн гэрээ байгуулж ажилласан байна. -Шинээр гэрээ байгуулах хүсэлт ирүүлсэн эмийн сангуудтай гэрээ байгуулсан байна.	Тайлант хугацаанд дараах эмийн сангуудтай гэрээ байгуулан ажиллаа. Үүнд: -2024 оны гэрээ дүгнэлтээр гэрээ үргэлжлүүлэн байгуулахаар болсон 32 эмийн сантай батлагдсан хуваарийн дагуу 2025 оны гэрээг баталгаажуулан гэрээний 1 хувийг эмийн сангуудад хүргүүлэн, гэрээг шилэн дансанд байршууллаа. -2025 онд албан хэрэг хөтлөлтийн able программаар Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээ байгуулах 47 хүсэлт ирсэн бөгөөд шалгуур хангасан 20 эмийн сантай шинээр гэрээ байгуулан баталгаажуулж, холбогдох тохиргоог эрүүл мэндийн даатгалын цахим програмд хийлгэн, баталгаажсан гэрээг шилэнд дансанд байршуулан ажиллаа. Мөн хаяг байршлаа өөрчилсөн 1, компаний эзэмшигч өөрчлөгдсөн 2 эмийн сантай нэмэлт гэрээ байгуулан ажиллаж, компани өөрчлөгдсөн шалтгаанаар гэрээ цуцлах хүсэлт ирүүлсэн 1 эмийн сангийн гэрээг цуцалсан. <i>Үр дүн:Тайлант хугацаанд нийт 82 эмийн сантай үндсэн болон нэмэлт гэрээг байгуулж, баталгаажсан гэрээг шилэн дансанд байршуулж ажиллаа.</i>	01.02 12.31	100

9.	<p>Батлагдсан төсвийн хүрээнд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудтай хэлцэл хийж, хүний нөөцийн чадавхи, хүчин чадлыг харгалзан үзүүлэх тусламж үйлчилгээний тоо хэмжээг оношийн хамааралтай бүлэг бүрээр тохирч гэрээнд тусгана.</p>	<p>Хэлцэл хийсэн ЭМБ-ын тоо-105</p>	<p>Хэлцэл хийсэн ЭМБ-ын тоо</p>	<p>Гэрээний талуудтай зөвшилцөх хэлцлийг хийсэн байна.</p>	<p><u>2025 онд хийсэн хэлцлүүд:</u></p> <p><u>Анхан шатны эрүүл мэндийн байгууллага:</u></p> <p>Бодлого төлөвлөлтийн газраас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 06/131 дугаартай дотоод албан бичиг, хавсралтаар өгсөн төсвийн хүрээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай 2025 оны гэрээг хийх шаардлагатай болсон. Энэ хүрээнд БТГ-аас ЭТҮ-нд 63,024,698,963, ЭМД-ын 4 тусламж, үйлчилгээнд 48,324,873,100 төгрөгийн төсөв хуваарилагдан ирсэн бөгөөд тус төсвийн мэдээллийг цэгцлэн гэрээний хэлцлийг хийхэд хялбар болгон цэгцэлж, гэрээлэлт хийх зааварчилгааг бэлтгэн хуваарийн дагуу холбогдох мэргэжилтнүүдэд өгсөн.</p> <p>555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас хуваарийн дагуу Дархан-Уул аймгийн 8, Хэнтий аймгийн 25, Булган аймгийн 18, Налайх дүүргийн 4, Багануур дүүргийн 3, Нийслэлийн 20 нийт 78 анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай 2025 оны гэрээний хэлцлийг хийж тус эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны төсвийн сарын хуваарийг сар бүрээр нь авч гэрээг баталгаажуулан шилэг дансанд байршуулсан.</p> <p>Мөн 2025 оны гэрээний хэлцлээ зөвшилцөөгүй нийслэлийн 11 өрхийн эрүүл мэндийн төв, Говь-Алтай аймгийн 3 сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны гэрээний мөнгөн дүнг дахин тооцооллуулах хүсэлтийг БТГ-т хүргүүлсэн.</p>	<p>03.01-04.01</p>	<p>100</p>
----	--	-------------------------------------	---------------------------------	--	--	--------------------	------------

				<p><u>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага:</u></p> <p>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудтай ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоол шинэчлэн батлагдаж 2025 оны 03 дугаар сарын 07-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой нэмэлт гэрээг 2025.03.07-2025.09.30 хүртэлх хугацаанд хийхээр болсон. Тус ажлын хүрээнд БТГ-аас ирүүлсэн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны гэрээний төсөвт холбогдох тохируулгуудыг БТГ-тай хамтран хийж гэрээ үргэлжлүүлэн байгуулах 298, 2024 онд зохион байгуулсан сонгон шалгаруулалтад тэнцсэн 23, нийт 321 эрүүл мэндийн байгууллагатай 2025 оны гэрээний хэлцлийг хийхээр болсон.</p> <p>Энэ хүрээнд хуваарийн дагуу нийслэлийн 22, Дархан-Уул аймгийн 12, Булган аймгийн 3, Хэнтий аймгийн 5, шинэ сонгонд тэнцсэн 1 нийт 43 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай нэмэлт гэрээний хэлцлийг хийж зөвшилцөн нэмэлт гэрээг хийн шилэн дансанд байршууллаа.</p> <p>Хуваарьт эрүүл мэндийн байгууллагуудаас сон медикал эмнэлэг, Супернова эмнэлэг, Амар мед эмнэлгүүд нь магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан шалтгаанаар хэлцэл хийгээгүй болно.</p> <p>Үр дүн: Тайлант хугацаанд анхан шатны 78, лавлагаа шатлалын 43, нийт 121 эрүүл мэндийн байгууллагатай гэрээний хэлцэл хийж зөвшилцлөө.</p>	
--	--	--	--	--	--

				<p>Хэлцлийн дагуу гэрээний тоо хэмжээ, мөнгөн дүнг эрүүл мэндийн даатгалын цахим системд тохиргоо хийлгэн, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулсан байна.</p>	<p>ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоол шинэчлэн батлагдаж 2025 оны 03 дугаар сарын 07-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор мөрдөгдөж байсан 689 оношийн хамааралтай бүлгийг шинээр батлагдсан тогтоол дах 700 оношийн хамааралтай бүлэг рүү хөрвүүлэх ажлыг хийж нийт 298 эрүүл мэндийн байгууллагын гэрээт оношийн хамааралтай бүлгийг шинэчлэн батлагдсан тогтоолын оношийн хамааралтай бүлэг рүү хөрвүүлэн 28969 оношийн хамааралтай бүлгийг эрүүл мэндийн даатгалын цахим програмд уншуулан тохиргоог хийлгэсэн.</p> <p><u>Анхан шатны эрүүл мэндийн байгууллага:</u> Анхан шатны 555 эрүүл мэндийн байгууллагатай 2025 онд хийсэн гэрээний үр дүнгээр эрүүл мэндийн байгууллагуудаас тухайн оны төсвийн сарын хуваарийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон ЭМДТХ-ийн 9.1.9-д заасан 4 тусламж, үйлчилгээг сар бүр хуваарилуулан авч нэгтгэн 555 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын төсвийн сарын хуваарийг Эрүүл мэндийн даатгалын цахим програмд уншуулж тохиргоог хийлгэсэн.</p> <p>ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоол шинэчлэн батлагдаж 2025 оны 03 дугаар сарын 07-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээ талд хуваарилагдсан төсвийг архаг, төлөвлөгөөт, цочмог үеийн тусламж, үйлчилгээгээр нь ангилах шаардлагатай болсон тул Бодлого төлөвлөлтийн газартай хамтран тухайн эрүүл мэндийн байгууллагын өмнөх оны архаг,</p>	04.01-12.31	
--	--	--	--	--	---	-------------	--

				<p>төлөвлөгөөт, цочмог тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн дүнг үндэслэн архаг, төлөвлөгөөт, цочмог тусламж, үйлчилгээний хуваарилалтыг хийн эрүүл мэндийн даатгалын цахим програмд 2025 оны 03 дугаар сараас тохируулга хийлгэсэн байсан. Тус тохируулгатай холбоотой эрүүл мэндийн байгууллагуудаас архаг тусамж, үйлчилгээнд төсөв хуваарилагдаагүй, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээний төсвөө бусад тусламж руу шилжүүлэх зэрэг олон санал хүсэлт ирсний дагуу 328 сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдээс архаг, төлөвлөгөөт, цочмог үеийн тусламж, үйлчилгээний төсвийн сарын хуваарийг саналыг дахин авч нэгтгэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний төсвийн сарын хуваарийг архаг, төлөвлөгөөт, цочмог тусламж үйлчилгээгээр нь 2025 оны 04 дүгээр сараас хойш хийх тохируулгыг эрүүл мэндийн даатгалын цахим програмд хийлгэлээ.</p> <p><u>Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага:</u> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ үргэлжилж буй 298, шинээр гэрээ байгуулах 23, нийт 321 лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай гэрээний хэлцэл хийхээс хэлцлээ зөвшөөрсөн 283 эрүүл мэндийн байгууллага, 2024 онд шинэ сонгон шалгаруулалтад тэнцсэн 21 эрүүл мэндийн байгууллага нийт 304 эрүүл мэндийн байгууллагын төсвийн сарын хуваарийг нэгтгэн Мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлж, эрүүл мэндийн даатгалын цахим програмд эрүүл мэндийн байгууллага</p>	
--	--	--	--	--	--

				<p>бүрийн сар бүрийн төсвийг архаг, цочмог, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээгээр нь 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2025.09.30-ний өдрийг хүртэл хугацаа төсвийг уншуулж холбогдох тохиргоог хийлгэсэн.</p> <p>Мөн төсвийн сарын хуваариа өөрчлүүлэх хүсэлт ирүүлсэн 23 эрүүл мэндийн байгууллагын төсвийн сарын хуваарийг албан хүсэлтийг үндэслэн өөрчлөн эрүүл мэндийн даатгалын цахим програмд тохиргоог шинэчлүүлэн дахин хийлгэсэн.</p> <p>Үр дүн: Анхан шатны 555 эрүүл мэндийн байгууллагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээгээр 63,024,698,963, ЭМДТХ-ийн 9.1.9-д заасан 4 тусламж, үйлчилгээгээр 48,324,873,100 төгрөгийн тусламж, үйлчилгээгээр, лавлагаа шатлалын 300 эрүүл мэндийн байгууллагуудтай 636,179,956,030.61 төгрөгийн тусламж, үйлчилгээгээр гэрээ байгуулж шилэн дансанд байршуулан ажиллаа.</p>		
			<p>Гэрээ цуцлах саналын хүрээнд хэлцэл хийж, гэрээг дуусгавар болгож шийдвэрлэсэн байна.</p>	<p>Тайлант хугацаанд Хэнтий аймгийн МЭИК-ээс эзэмшигч буюу улсын бүртгэл өөрчлөгдсөн шалтгаанаар гэрээ цуцлах хүсэлт ирүүлсний дагуу ХЭ-04/1344 дугаартай даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг цуцаллаа.</p> <p>Үр дүн: Тайлант хугацаанд 1 эмийн сантай хэлцэл хийж гэрээг дуусгавар болголоо.</p>	01.02-12.31	
				<p>2025 онд нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тус сонгон шалгаруулалтад ашиглах програмын шинээр хийлгэх, эсвэл хуучин</p>		

10.	Нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохих хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар зохион байгуулна.	Тэнцсэн эрүүл мэндийн байгууллагуудын тоо (төрлөөр)	Лавлагаа шатлалын 328 эрүүл мэндийн байгууллага сонгон шалгаруулалт ад тэнцсэн.	Нэгдсэн сонгон шалгаруулалтыг зарлахад шаардагдах програмын бэлэн байдлыг хангахад шаардлагатай бэлтгэл ажлуудыг зохион байгуулах.	<p>програмыг хөгжүүлэн цаашид ашиглах боломжтой эсэх асуудлыг 2025 оны 02 дугаар сард Мэдээллийн технологийн хэлтсийн дарга болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийн бүтэц, үйл ажиллагааг танилцуулсан. Мэдээллийн технологийн хэлтсээс тус програмын хөгжүүлэлтийг хийх болон өөр шинэ програм бичих боломжгүй гэсэн мэдээллийг хэлсэн. Иймээс сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийг хийсэн Ай Өү ХХК-ийн захирал н.Энх-Амгалан болон холбогдох асуудал хариуцсан албан тушаалтнуудтай 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр МТХ-ийн хэлтсийн дарга Бат-Оргилтой хамт уулзан цаашид тус програмыг хэрхэх талаар санал солилцлоо. Програм хөгжүүлэгчийн зүгээс одоо ашиглаж байгаа сонгон шалгаруулалт, гэрээлэлтийн цахим програм www.selection.1818.mn-ийг цаашид хөгжүүлэх, эсвэл түүнтэй ижил төстэй сайжруулсан програм хангамж нийлүүлэхэд хэдий хэмжээний төсөв шаардлагатай талаарх үнийн саналыг авлаа.</p> <p><i>Үр дүн: Нэгдсэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ашиглагдан програм хангамжийн талаар зөвшилцөх уулзалтуудыг хийж, үнийн саналыг авлаа.</i></p>	04.01-07.01	95
11.	БСТ-3.1.2 2025 оны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах	-Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо	2024 оны гэрээт эрүүл мэндийн байгууллагын гэрээг дүгнэж,	-	Хугацаа болоогүй	11.01-12.31	-

	гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг ажлыг зохион байгуулна.	-Гэрээний хэрэгжилтийн хувь	хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.				
Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.							
12.	БСТ-3.2.3 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн, даатгуулагчийн гомдол, саналд хийсэн дүн шинжилгээний үр дүнд үндэслэж гэрээлэгч байгууллагад газар дээрх хяналт хийнэ.	Хяналт шалгалтад хамрагдсан ЭМБ-ын тоо	Хяналт шалгалтад хамрагдсан ЭМБ-ын тоо-5	Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хуваарийн дагуу болон төлөвлөгөөт бус газар дээрх хяналт шалгалтыг тухай бүрт хийж, зерчил дутагдлыг арилгасан байна.	Худалдан авалт, гэрээлэлтийн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 10-00-07/08 дугаартай “Диализийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй зарим хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт, шалгалт хийх тухай” хяналт шалгалтын удирдамжийн дагуу Их шүүдэргэнэ импорт ХХК-ийн Медвик эмнэлэг холбогдох мэргэжилтнүүдийн хамт газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Ихшүүдэргэнэ импорт ХХК-ийн Медвик эмнэлэгт эмнэлгийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд заагдсан Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, С.Зоригийн гудамж-2 байршилд газар дээр нь очиж хяналт хийхэд 4 эмч, 10 сувилагч, 1 инженер, 2 техникчтэй, гемодиализийн 46 аппараттай үйл ажиллагаа явуулж байсан. Хяналтаар Улсын гуравдугаар төв эмнэлгийн 1 давхарт тус эмнэлгийн Медвик-2 салбар нь гемодиализийн 40 аппараттай үйл ажиллагаа явуулж байсан ба тухайн байршил дээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа зөрчлийг илрүүлж Эрүүл мэндийн яам болон Нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээллээ.	01.02 12.31	92

					<i>Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан ЭМБ-ын тоо-1</i>		
13.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж, ЭМДҮЗ-ийн тогтоолтой нийцүүлэн “Газар дээр нь очиж хийх хяналт шалгалтын журам”-ыг шинэчлэн батлана.	Шинэчлэн батлагдсан журам	-	-	Хугацаа болоогүй.	07.01 12.31	-
14.	Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	-	Зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	Тайлант хугацаанд гэрээт эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хэрхэн гэрээ байгуулах, сонгон шалгаруулалтад хэрхэн оролцох зэрэг мэдээлэл зөвлөгөө авахаар ирсэн болон утсаар холбогдсон эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаа. <i>Үр дүн: Зөвлөн туслаж, холбогдох мэдээллээр ханган ажиллаа.</i>	01.02- 12.31	100
15.	<i>БСТ-3.2.4</i> Өвөрхангай аймаг дахь ЭМДХ, Багануур, Налайх дүүрэг дэх эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, зөвлөн тусална.	Хяналт шалгалт, хийсэн нэгжийн тоо	-	-	Хугацаа болоогүй.	07.01- 12.31	-

Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө.

16.	Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна.	-Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, - Хэрэгжилтийн хувь	-	Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.	Албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөнө гаргах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 онд Монгол бичгийн сургалтад хамрагдсан. Үр дүн: Хос бичгээр албан бичгийг боловсруулах бэлтгэж ажлууд хийгдэж байна.	01.02-12.31	60
17.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.	Хэрэгжилтийн хувь	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана.	Хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаанд нь тайлагнаж, тус газарт хамаарах заалтын хэрэгжилтийг ханган тайлагнасан байна.	2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд гарган үнэн зөв тайлагнасан. Тайлант хугацаанд манай газарт хамаарах заалтын хэрэгжилтийг гаргах талаарх тайлан ирээгүй болно. Үр дүн: ХАСХОМ-ын мэдүүлгээ хугацаанд нь тайлагнан ажиллаа.	01.02-12.31	100
18.	БСТ-1.2.3 Даатгуулагч-иргэн, гэрээт байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тодорхойлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ .	-Судалгаанд хамрагдсан иргэн, байгууллагын тоо -Үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн байгууллагууд аас авсан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авч байгаа QR бүхий сэтгэл ханамжийн судалгааг өөрийн ширээ болон ерөөний үүдэнд байршуулан гэрээний хэлцэл хийхээр ирсэн болон бусад асуудлаар ирсэн эрүүл мэндийн байгууллагуудаас тогтмол бөглүүлж ажиллаж байна. Үр дүн: Хэлцэл хийхээр ирсэн анхан шатны 20, лавлагаа шатлалын 21, гэрээ байгуулахаар ирсэн 52 эмийн сан нийт 93 байгууллагаар сэтгэл ханамжийн судалгаа авсан.	01.02-12.31	100

19.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг шийдвэрлэнэ.	Шийдвэрлэлтийн хувь		Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Тайлант хугацаанд 9 өргөдөл гомдол албан хэрэг хөтлөлтийн able програмаар цохогдон ирснээс 5 өргөдөл Засгийн газрын 11-11 төвөөс, 2 өргөдөл 1800-1363 төвөөс, 2 өргөдөл цаасан хэлбэрээр ирсэн байсан бөгөөд тус гомдлуудыг хуулийн хүрээнд шийдвэрлэн иргэнд хариуг өгч ажиллаа. 2025 онд албан хэрэг хөтлөлтийн able програмаар нийт 180 албан бичиг ирсэн. 172 албан бичгийг шийдвэрлэн, 8 бичгийг шийдвэрлэх шатандаа явж байна. Албан бичгийн шийдвэрлэлт 95,5 хувьтай байна. Албан хэрэг хөтлөлтийн able програмаар 88 албан бичгийг төлөвлөн холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаа. Тайлант хугацаанд нийт 111 дотоод бичгийг боловсруулан холбогдох хэлтэс, газар, орон нутаг дах ЭМДХ-үүдэд хүргүүлэн ажилласан. <i>Үр дүн: Нийт 9 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаа. Албан бичгийн шийдвэрлэлт 95.5 хувьтай байна.</i>	01.02-12.31	100
20.	Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, хяналт тавин ажиллана.	Шилэнд дансанд байршуулсан гэрээний тоо		Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, байгуулсан гэрээг шилэн дансанд байршуулна.	2025 онд шилэнд дансанд дараах гэрээг шилэн дансанд байршуулан мэдээллийг ил тод байдлыг ханган ажиллаа. Үүнд: - Эмийн сангийн гэрээ -1510 - Эмийн сангийн нэмэлт гэрээ- 8 - Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын гэрээ- 555 - Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэмэлт гэрээ-4 - Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын нэмэлт болон үндсэн гэрээ-304	01.02-12.31	100

					<i>Үр дүн: Нийт 2381 гэрээг шилэн дансанд байршуулан ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллаа.</i>		
21.	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.	Цахим гарын үсгээр албажсан албан бичиг, гэрээний тоо	-	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн даатгалын цахим програмаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад 2025 оны гэрээнд цахим гарын үсгийг нэвтрүүлэх болсон талаарх мэдээллийг хүргүүлж бэлтгэл ажлын хангаж ажиллах талаар санамжийг хүргүүлсэн. Цаашид бусад гэрээг цахим хэлбэрт шилжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. <i>Үр дүн: Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай 2025 онд байгуулж байгаа нэмэлт гэрээг цахим хэлбэрээр хийсэн.</i>	01.02-07.01	100
				Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээг цахим гарын үсгээр баталгаажуулан, байгуулна.	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай 2025 онд байгуулж байгаа нэмэлт гэрээг цахим хэлбэрээр хийсэн бөгөөд 283 нэмэлт гэрээг цахим гарын үсгээр баталгаажуулан шилэн дансанд байршуулан ажиллаа. Мөн албан хэрэг хөтлөлтийн able програмаар 96 албан бичгийг цахимаар төлөвлөн холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаа. <i>Үр дүн: Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо-109, Цахимаар хийсэн гэрээний тоо-283</i>	03.01-12.31	100
Бусад. Албан тушаалын тодорхойлолтын зорилтод тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд:							
22.	Төвлөрөл сааруулах бодлогын хүрээнд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын үндэсний багтай	Шийдвэрлэлтийн хувь Санхүүжилтийн мөнгөн дүн	-	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын үндэсний багтай хамтран үзүүлсэн	Төвлөрөл сааруулах бодлогын хүрээнд гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу эрүүл мэндийн даатгалын цахим системд дараах оношийн хамааралтай бүлгүүдийг түр нээлгэх		

	<p>хамтран үзүүлсэн тусламж үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.</p>			<p>тусламж, үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн, бүртгэлжүүлнэ</p>	<p>тохиргоог хийлгэн, хүсэлтийг шийдвэрлэн ажиллаа. Үүнд: - 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн 2025.02.18-ны өдрийн 99 дугаартай албан бичиг болон Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвөөс нэмэлтээр ирүүлсэн баримт материалд үндэслэн тус дүүргийн эрүүл мэндийн төвөөс тусламж, үйлчилгээ авч буй иргэн Энхболд овогтой Цэлмэг Ш387051068, Батсайхан овогтой Ариунтөгс ИО910902103 нарт үзүүлэх 51010292 ОХБ-г 2025.02.25-ны өдрөөс 2025.03.03-ны өдрийг дуусталх хугацаанд түр нээлгэсэн. - 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрээнд заагдаагүй 621164302 оношийн хамааралт бүлгээр иргэн Д.Буянхишигт /Per:ШД71062902/-т мэс заслын тусламж, үйлчилгээг яаралтай журмаар үзүүлсэн байх тул ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тусламж үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн, төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх удирдамжийн 5.1-т заасны дагуу уг оношийн хамааралт бүлгийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд түр нээлгэсэн. - 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвөөс</p>	<p>03.01-12.31</p>	<p>100</p>
--	---	--	--	--	--	--------------------	------------

					<p>ирүүлсэн 2025.03.21-ний өдрийн 186 дугаартай албан бичиг болон Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвөөс тусламж, үйлчилгээ авч буй иргэн Энхболд овогтой Цэлмэг Ш387051068, Батсайхан овогтой Ариунтөгс ИО910902103, Нэргүй Ганбат ХЛ76120270 нарт үзүүлэх 621010292 ОХБ-г 2025.03.25-ны өдрөөс 2025.04.24-ны өдрийг дуусталх хугацаанд түр нээлгэсэн.</p> <p>- 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /ID-630 төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ/ нь Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж хүүхдийн бөөр шилжүүлэн суулгах гэж байгаа талаарх мэдээллийг манай газарт ирүүлсэн. Хүсэлтэд дурдсан 6232343542 оношийн хамааралтай бүлгээс тус эмнэлэг нь гэрээгүй байсан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолын Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тусламж үйлчилгээний зардлын бүрэлдэхүүн, төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалтын мэс заслын тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд баримтлах зарчимд Зөвхөн нутгийн эрүүл мэндийн байгууллага нь зайлшгүй шаардлагаар даатгалын байгууллагатай гэрээгүй мэс заслын ОХБ-ээр нэхэмжлэл илгээж, санхүүжүүлэх зохицуулалтыг тусгасан</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>байсан тул тухайн тусламж, үйлчилгээг нээх боломжгүй байсан тул Бодлого төлөвлөлтийн газарт 2025.05.13-ний өдрийн 07/814 тоот албан бичгээр тус эмнэлгийн үзүүлэх тусламж, үйлчилгээг ЭМД-ын цахим програмд нээх эсэх талаарх чиглэлийг хүссэн албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус албан бичгийн хариуг 2025.05-ны өдрийн 06/817 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Иймд тус гэрээгүй 6232343542 оношийн хамааралтай бүлгээр иргэн Шижирбаатар овогтой Аялгуу РД:УК11301601 үзүүлсэн тусламж, үйлчилгээг нэхэмжлэх эрхийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 16-ний өдрийг дуусталх хугацаанд түр нээлгэсэн.</p> <p><i>Үр дүн: Тайлант хугацаанд 6 иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийг эрүүл мэндийн даатгалын цахим програмд нээж 13 471 140 төгрөгийн тусламж, үйлчилгээг иргэнд ЭМД-аар үзүүлэх боломжоор хангаж тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллаа.</i></p>		
23.	Гэрээт лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах нэмэлт гэрээ байгуулах хүсэлтийг судалж, тусламж үйлчилгээний	Нэмэлт гэрээ байгуулсан ЭМБ-ын тоо	-		<p>- Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тус эмнэлгийн хүсэлтэд дурдсан 621234381 (Хавдрын дараах химийн бай эмчилгээ (эмээс бусад тусламж, үйлчилгээ), 621340031 (Өдрөөр хийх хорт хавдрын химийн бай эмчилгээ (эмээс бусад тусламж, үйлчилгээ) оношийн хамааралтай бүлгүүдээр тусламж үйлчилгээ үзүүлэх чадамж /хүний нөөц, тоног төхөөрөмж, тусгай нэгж байгууламж/-ийг газар дээр</p>	01.02-12.31	100

	эрэлт хэрэгцээн дээр тулгуурлаж шийдвэрлэнэ.				<p>нь үнэлэхээр шийдвэрлэсэн талаарх албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 05/1143 тоот албан бичгээр тус байгууллагад хүргүүлж, Дархан-Уул аймаг дах ЭМДХ-т газар дээрх хяналт хийх тухай албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 07/835 дугаартай дотоод албан бичгээр ирүүлсэн ба ДА-01/001-0324 дугаартай нэмэлт гэрээг байгуулан ажиллаа.</p> <p>- Нийслэлийн Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвөөс удаа дараа ирүүлсэн хүсэлтийн дагуу тархмал хатуурал оноштой иргэнд үзүүлж буй тусламж үйлчилгээний чадамжийн мэдээллийг албан бичгээр авч, үнэлсний дагуу тус эрүүл мэндийн төвтэй 621010292 оношийн хамааралтай бүлгээр УБ-01/023-0325 дугаартай нэмэлт гэрээг байгуулан ажиллаа.</p> <p>Үр дүн: Нэмэлт гэрээ байгуулсан ЭМБ-ын тоо-2</p>		
Албан тушаалын тодорхойлолтын зорилт 5-д, "Дотоод зохион байгуулалтын ажилд оролцох, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд:							
24.	Архивын нэгж бүхий баримт бичгүүдийг стандартын дагуу архивлана.	Архивын нэгж бүрдүүлэлтийн тоо	Архивын нэгж бүрдүүлэлтийн тоо-6	Архивын нэгж бүрдүүлэн ажиллана.	<p>Анхан шатны мэндийн байгууллагуудын 2024 оны үнэлгээний дүнгийн илтгэх хуудсыг архивлан 3 архивын нэгж бүрдүүлсэн. 2024 онд хийсэн газар дээрх хяналтын материалуудыг архивлан архивын 3 нэгж бүрдүүлсэн.</p> <p>Үр дүн: Архивын нэгж бүрдүүлэлтийн тоо-6</p>	01.02-12.31	100
25.	Хариуцсан асуудлаар	Хэрэгжилтийн хувь	-	Дотоод ажил үргийн	Батлагдсан дотоод ажлын хуваарийн дагуу Дархан-Уул, Хэнтий, Булган аймаг, Налайх		

	<p>батлагдсан дотоод ажил үүргийн хуваарийн дагуу чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах.</p>			<p>хуваарийн дагуу чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.</p>	<p>дүүргийг хариуцан ажилладаг бөгөөд тус ажлын хүрээнд Орон нутаг дах ЭМДХ болон тус аймагт байршилтай ЭМДЕГ-тай гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын гэрээлэлт, гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар мэдээллээр ханган мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна.</p> <p>Хариуцсан орон нутгуудын эрүүл мэндийн байгууллагуудаас албан хэрэг хөтлөлтийн able програмаар ирүүлсэн 49 албан бичиг, дотоод албан бичгээр ирүүлсэн 8 албан бичиг нийт 57 албан бичгийг шийдвэрлэн ажиллаа.</p> <p>Мөн эмийн сан, анхан шатны эрүүл мэндийн байгууллага, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны гэрээ байгуулахтай холбоотой бэлтгэл ажлын хүрээнд Орон нутаг дах ЭМДХ-үүдэд гэрээний төсөл, төсөв болон холбогдох материалуудыг бэлтгэн хүргүүлж гэрээг байгуулахад анхаарах зүйлсийн талаар мэдээлэл өгч, мэргэжил аргазүйгээр хангаж ажиллаа.</p> <p>Үр дүн: Хариуцсан аймагтай холбоотой асуудлуудыг тухай бүр нь шийдвэрлэн ажиллаа.</p>	<p>01.02-12.31</p>	<p>100</p>
--	--	--	--	---	--	--------------------	------------

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх, дуусах огноо
	1	2	3	3	4	5

“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд:

1.	Газар, хэлтсийн хэмжээнд болон чиг үүргийн хүрээнд явагдах сургалт, семинарт оролцож, шинэчлэгдсэн хууль, тогтоомж, дүрэм, журам, заавартай танилцаж судлах.	Хамрагдсан сургалтын тоо	Хамрагдсан сургалтын тоо-10	2025 онд Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас зохион байгуулсан дотоодын 5 удаагийн сургалтад хамрагдсан. АШУУИС-ын НЭМС-д докторантаар суралцаж байна. Үр дүн: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтуудад тухай бүр нь хамрагдлаа.	01.02-12.31
----	--	--------------------------	-----------------------------	---	-------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ГЭРЭЭЛЭЛТ,
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)

 /Д.МӨНХТУЯА/

(Нэр, гарын үсэг)

2025.05.28

(Огноо)